*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: *Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар*

Нэгжийн нэр: *Газрын судалгаа шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газар*

**1.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох”** | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ 1.2. Газар зохион байгуулалт, суурь судалгаа, мониторинг, газрын кадастрын, хот байгуулалтын чиглэлээр боловсруулагдаж буй журам, заавар, аргачлалд санал өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 2. “Газрын харилцааны салбарын бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангах”** | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр оруулах саналыг боловсруулах | 60 | 10 | 70 | |
| 4 | Арга хэмжээ 2.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулах | 50 | 10 | 60 | |
| 5 | Арга хэмжээ 2.3. "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө"-г (2025-2028) боловсруулж, батлуулах | 40 | 10 | 50 | |
| **Зорилт 3. “Салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хууль тогтоомж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, зорилт, арга** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, зөвлөмж гаргах” | | | | | |
| 6 | Арга хэмжээ 3.1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хэрэгжилтийг гаргаж тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 7 | Арга хэмжээ 3.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнах | 50 | 10 | 60 | |
| 8 | Арга хэмжээ 3.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг гаргаж тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 9 | Арга хэмжээ 3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4. “”Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх”** | | | | | |
| 10 | Арга хэмжээ 4.1. “Бүсчилсэн хөгжлийг дэмжих - Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 5. “Хурал, зөвлөгөөн зохион байгуулах”** | | | | | |
| 11 | Арга хэмжээ 5.1. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 12 | Арга хэмжээ 5.2. Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 13. | Арга хэмжээ 5.3. Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх санал боловсруулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 6. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх”** | | | | | |
| 14 | Арга хэмжээ 6.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 15 | Арга хэмжээ 6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Арга хэмжээ 6.3.<br>Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | 60 | 10 | 70 | |
| 17 | Арга хэмжээ 6.4.<br>Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | 60 | 10 | 70 | |
| 18 | Арга хэмжээ 6.5.<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 19 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын тайланг нэгтгэн, нэгдсэн тайланг гарган, танилцуулга бэлдэн Газрын даргын дэргэдэх Зөвлөлийн хуралд танилцуулах | 60 | 10 | 70 | |
| 20 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br>Монгол Улсын Ерөнхий сайд тус газарт ажиллахтай холбогдуулан Ерөнхий сайдаас өгөх үүрэг, чиглэлийн төслийг боловсруулах | 60 | 10 | 70 | |
| 21 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.<br>Тус газрын дэргэд ажиллах Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулах, зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах | 60 | 10 | 70 | |
| 22 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.<br>Тус газрын стратегийн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн батлагдсантай холбогдуулан шинээр бий болсон болон шинэчлэгдсэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, хянах | 60 | 10 | 70 | |
| 23 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.<br>Газрын харилцааны салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойд зориулсан номын хэвлэлийн эх бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллан хуваарийн дагуу мэдээ мэдээлэл бэлтгэх | 60 | 10 | 70 | |
| 24 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.<br>Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн баярын хуралд оролцох хүмүүсийн нэрс гаргаж удирдлагад танилцуулах | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 68,3 | |

## 2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдах | 100 | 10 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Монгол хэл бичгийн сургалтанд хамрагдах, бие даан суралцах | 80 | 10 | |
| **Дундаж оноо** | | | 10 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 15 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 15 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 15 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 15 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| **Дундаж оноо** | | 15 | |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 68,3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 10 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 15 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | 93,3 (........ оноо) |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 93,3 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ,
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА ..................... /А.АМАРСАЙХАН/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.05
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ,
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ..................... /Х.ЭНХЖАРГАЛ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.05
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***
*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч*

..................... ..................... /...................../
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.19.
*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

..................... ..................... /...................../
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.19.
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ..................... /А.ЭНХМАНЛАЙ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.20
*(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын*
*2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох”** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/77 дугаар тушаалаар батлагдсан “Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг хэлтсүүдэд танилцуулан орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулах талаарх чиглэлийг өгсөн.<br>Газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалаар батлуулсан 70 бүтээлч ажлын төлөвлөгөөг байгууллагын Able системд байршуулан хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг хэлтсүүдэд өгсөн.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн нэгтгэлийг хянаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар хүргүүлсэн бөгөөд олон нийтийн хүртээл болгох зорилгоор хэвлүүлэх ажлыг заавар, арга зүйгээр хангаж, хэвлэлийн эх бэлтгэлийг хянах ажлыг хийж гүйцэтгэлээ. | 02.15-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 1.2. Газар зохион байгуулалт, суурь судалгаа, мониторинг, газрын кадастрын, хот байгуулалтын чиглэлээр боловсруулагдаж буй журам, заавар, аргачлалд санал өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах | Санал өгсөн баримт бичгийн тоогоор | - | Хэлтсүүдийн шинээр боловсруулсан болон шинэчлэн найруулсан журам, заавар, аргачлалд санал өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас боловсруулан санал авахаар ирүүлсэн "Газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн ажиллах журам", "Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам"-тай танилцан санал боловсруулж, Хуулийн хэлтэст өгсөн.<br>Газрын даргын 2023 оны А/194 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд боловсруулагдсан "Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-ын төсөл, мөн газрын даргын 2023 оны А/198 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд боловсруулагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын төсөлд холбогдох саналыг өгч ажилласан.<br>Төрийн захиргаа, удирдлагын газартай хамтран "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, газрын кадастрын салбарын мэргэжилтний мэргэжлийн чиглэлээр давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийг боловсруулахад оролцон ажилласан.<br>"Геодези, зураг зүй, газар зохион байгуулалт, орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2024 оны А/77, "Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн ажиллах журам"-ыг холбогдох мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, газрын даргын 2024 оны А/120 дугаар тушаалаар батлуулсан.<br>2024 оны 9 дүгээр сарын 02-ноос 06-ны өдрүүдэд тус газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Энхтуяатай хамтран "Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам", "Газар эзэмших, ашиглах эрхийн | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гэрчилгээ олгох журам"-ын төслүүдийг дахин шинэчлэн боловсруулсан. | | |
| **Зорилт 2. "Газрын харилцааны салбарын бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангах"** | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр оруулах саналыг боловсруулах | 1 хөтөлбөр | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр | Үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах саналыг боловсруулах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дүгнэлтийг гаргахад шаардлагатай 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвслээс мөрийн хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр тусгах асуудлын саналыг хэлтсүүдээс авч нэгтгэсэн саналыг хянан, холбогдох газарт, мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах саналыг хүргүүлэн ажилласан. | 03.01-09.30 | 90 |
| 4 | Арга хэмжээ 2.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулах | Жилийн төлөвлөгөөний төсөл | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний төслийг Санхүү, эдийн засгийн хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, салбарын өнөөгийн байдал, тоон мэдээллийг 2018-2023 оны байдлаар, мөн салбарын 2024-2025 оны хөгжлийн төсөөлөл, салбарын 2025-2027 оны хөгжлийн төсөөлөл, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, салбарт тулгарч болзошгүй эрсдэл зэрэг асуудлын танилцуулгыг бэлтгэн төлөвлөгөөний төсөлд хавсаргасан.<br>Тухайн төлөвлөгөөний төслийг тус газрын 2024 оны 1/124 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 01.02-01.30 | 100 |
| 5 | Арга хэмжээ 2.3. "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги | 1 төлөвлөгөө | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025- | Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Стратеги | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө"-г (2025-2028) боловсруулж, батлуулах | | (2021-2024)-г 2021 онд БХБ-ын сайдаар батлуулсан. | 2028)-г боловсруулж, батлуулсан байна. | төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх хуваарийг гарган газрын даргаар батлуулав.<br>Тухайн стратегийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Газрын даргын 2024 оны А/264 дүгээр тушаалаар байгуулж, уг тушаалын хавсралтаар төлөвлөгөө боловсруулах хуваарийг батлуулав.<br>Батлагдсан хуваарийн дагуу стратегийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мандатын шинжилгээг хийж, холбогдох хууль тогтоомжоос тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлон, тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилан салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Мөн кадастр, газрын үнэлгээ, төлбөр, газрын биржийн үйл ажиллагааны хүрээнд стратегийн зорилго, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдааг гаргах ажлыг хийсэн. Дээрх судалгаан дээр суурилан кадастр, газрын биржийн үйл ажиллагааны хүрээнд байгууллагын 4 жилийн стратегийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг хийж байна. | 08.15-12.10 | 60 |
| **Зорилт 3. "Салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хууль тогтоомж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, зөвлөмж гаргах"** | | | | | | | |
| 6 | Арга хэмжээ 3.1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл | Үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд газрын | 01.02-12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хэрэгжилтийг гаргаж тайлагнах | | ажиллагааны хөтөлбөр батлагдсан. | хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | харилцааны чиглэлээр тусгагдсан нийт ажлуудын биелэлтийг асуудал хариуцсан нэгжүүдээс гаргуулах, нэгтгэх ажлыг холбогдох хугацаанд нь хийж тайлагнах ажлыг холбогдох мэргэжилтэнтэй хамтран хийж гүйцэтгэсэн. | | |
| 7 | Арга хэмжээ 3.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнах | Төлөвлөгөөний биелэлт | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлагдсан. | Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнасан байна. | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд газрын харилцааны чиглэлээр туссан ажлуудын биелэлтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, тайлагнах ажилд оролцож ажилласан. | 07.01-09.30 | 90 |
| 8 | Арга хэмжээ 3.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг гаргаж тайлагнах | Газрын харилцаатай холбоотой бүх тогтоол, шийдвэр | - | Тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг гаргаж, тайлагнасан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг тухай бүр тайлагнан ажиллаж байна. Байгууллагын удирдлагаас үүрэг болгосоны дагуу Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийн байдлын талаарх танилцуулгыг бэлдэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br>Мөн Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тэмдэглэлийн биелэлт, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажилласан. | 01.02-12.10 | 90 |
| 9 | Арга хэмжээ 3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих | Батлагдсан төсвийн хүрээнд | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж буй ажлуудын явцад хяналт тавьж хэрэгжилтийг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэх ажлуудын сонгон шалгаруулалт 1-р улиралд зарлагдсан бөгөөд гүйцэтгэлийн гэрээ байгуулах ажлууд хийгдэж дууссан.<br>Монгол Улсын Сангийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх дараах төсөл, арга хэмжээний саналыг нэгжүүдээс | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хангаж ажилласан байна. | авч нэгтгэн Санхүү, эдийн засгийн хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд дараах төслүүдийн мэдээллийг оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Газрын биржийн цахим системийн хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн шинэчлэл;<br>- "Улсын хэмжээнд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх";<br>- "Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх". | | |
| **Зорилт 4. “”Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх”** | | | | | | | |
| 10 | Арга хэмжээ 4.1. “Бүсчилсэн хөгжлийг дэмжих - Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласан. | Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан холбогдох нэгжүүдтэй хамтран хэрэгжилтийг зохион байгуулсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”, мөн тус газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх газрын даргын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг боловсруулан Газрын даргаар батлуулсан.<br>Албан даалгаврыг тус газрын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/459 тоот албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн. | 01.20-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Газрын даргын 2024 оны А/04 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд боловсруулсан “Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын сарын 27-ны өдрийн 482 дугаар тогтоолоор Үндэсний орон сууцжуулалтын Үндэсний хороог байгуулсантай холбогдуулан орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр газрын харилцааны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгч батлуулсан.<br>“Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд гаргасан газрын даргын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг гаргах зорилгоор нийслэлийн ГЗБА болон 21 аймгийн ГХБХБГ-т тус газрын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний “Албан даалгаврын хэрэгжилт, тайлан ирүүлэх тухай” 1/3177 дугаар албан бичгийг хүргүүлэв. | | |
| **Зорилт 5. “Хурал, зөвлөгөөн зохион байгуулах”** | | | | | | | |
| 11 | Арга хэмжээ 5.1. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | Хуралдааны тоо<br>- Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл | 2023 онд Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл 6 удаа хуралдсан. | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, орон зайн мэдээлэл технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, Газрын даргын 2024 оны А/77 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.<br>Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах зарыг байгууллагын цахим системд анкетын хамт зөвлөлийн гишүүдийг сонгох ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22- | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрийн А/176 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>Тус зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүний анхдугаар хурлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, мэргэжлийн зөвлөлийн дарга болон орлогч даргыг сонгон 2024 онд тухайн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг хэлэлцүүлэв. Тус хурлаас гарсан шийдвэрийн дагуу зөвлөлийн дарга, орлогч даргыг газрын даргын 2024 оны А/197 дугаар тушаалаар баталгаажуулав. Мөн 2024 онд тухайн зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд шаардлагатай зардлын тооцоог гарган дээрх тушаалын хавсралтаар батлуулсан. Орон тооны бус зөвлөлийн хурлаар 2024 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна.<br>Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж 6 асуудал, 08 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж 3 асуудал, 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж 3 асуудлыг тус хэлэлцүүлэв. Тухайн хурлуудын тэмдэглэлийг бичиж, шийдвэрийг Зөвлөлийн даргаар албажуулан холбогдох хэлтэст хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Байгууллагын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг 2024 оны 11 дүгээр 18-ний өдөр хуралдуулж, "Газар зүйн нэрийг тодотгох, тогтоох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох дүрэм"-ийн төслийг хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулан холбогдох хэлтэст өгөв. | | |



107

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Арга хэмжээ 5.2. Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах | Төлөвлөгөө, арга хэмжээний тоо | "Газрын харилцааны ажилтны өдөр"-ийг 2023 оны 4, 5 дугаар сард зохион байгуулсан. | Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ой, Газрын харилцааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж, арга хэмжээг зохион байгуулсан байна. | - Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд хийж гүйцэтгэх 70 бүтээлч ажлын саналыг агентлагийн газар, хэлтсүүд, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн ГХБХБГ-аас санал авч нэгтгэн боловсруулж, газрын даргын дэргэдэх Зөвлөлийн хуралд танилцуулан Газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалаар батлуулан, тус газрын 2024 оны А/364 тоот албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг өгсөн.<br>- Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ой, Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан "Ж.Наранцацралт багшийн нэрэмжит газрын харилцааны салбарын оюутны эрдэм шинжилгээний хурал - 2024" эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсын Их сургуулийн Газарзүйн тэнхим, Наранцацралт сантай хамтран зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан талаарх мэдээлийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулсан.<br>- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоотой хамтран зохион байгуулсан Баянзүрх дүүргийн "Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн"-нд геодези, зураг зүйчдийн нэрэмжит төгөл байгуулах үйл ажиллагаанд оролцсон. | 01.02-12.310 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Тухайн арга хэмжээний хүрээнд Хөдөө аж ахуйн их сургууль дээр зохион байгуулагдсан "Газрын харилцаа 2024" эрдэм шинжилгээний хурлын "Кадастртай холбоотой асуудлууд" салбар хуралдаанд оролцсон.<br>- 70 жилийн ойн хүрээнд ном, товхимол бэлтгэн гаргах ажлын хэсэгт ажиллаж, хуваарилагдсан мэдээллүүдийг гаргаж ажлын хэсгийн ахлагчид өгсөн.<br>- Төрийн ордонд зохион байгуулагдах газрын мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн баярын хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллаж байна. | | |
| 13 | Арга хэмжээ 5.3. Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх санал боловсруулах | Олон улсын туршлага | - | **Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх санал боловсруулж,** нэвтрүүлсэн байна. | Олон улсад гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын аж ахуйн нэгжид газар эзэмшүүлж, ашиглуулах талаарх гадаад орны эрх зүйн орчны судалгааг 3 орны жишээн дээр судалсан. Үүнд: ОХУ, Хятад, Казакстан улс.<br>Гурав болон дөрвөн хэмжээст кадастр болон бүртгэлийг хэрхэн хийх талаар олон улсын туршлагыг судалсан бөгөөд Австрали, БНХАУ, Болгар, Нидерланд, БНСУ, Сингапур, Беларусь, Малайз, Норвеги, Швед зэрэг улсуудын кадастрын систем, гурав болон дөрвөн хэмжээст кадастрын бүртгэлийн систем, өнөөгийн эрх зүйн орчны байдал, гурван хэмжээст обьектын бүртгэл, гурван хэмжээст обьектын хууль, эрх зүйн тодорхойлолт, гурван хэмжээст хэлбэрээр бүртгэж болох эрхийн төрлүүд, гурав хэмжээст бүртгэлийн талаарх өмнө хийсэн судалгааны материалыг эмхэтгэсэн бөгөөд ОХУ-ын туршлагыг нэмж судалсан. | 01.02-09.30 | 100 |
| **Зорилт 6. "Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх"** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ 6.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | Тус газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, газрын шуурхай зөвлөгөөн, газар, нэгжийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн, тайлагнан ажиллаж байна.<br>Байгууллагын шуурхай зөвлөгөөнөөс тус газарт өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног бүрийн Пүрэв гарагт Able системд оруулан ажиллаж байна. | 01.02-12.10 | 100 |
| 16 | Арга хэмжээ 6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Газрын даргын тушаалаар байгуулагдсан дараах ажлын хэсгүүдэд ажилласан байна. Үүнд:<br>- Газрын даргын 2023 оны А/194 дүгээр тушаалаар байгуулагдсан "Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн ажиллах журам" боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2023 оны А/198 дугаар тушаалаар байгуулагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар байгуулагдсан "Орон сууцны хүртээмжийг "5М" зэргээр төрөлжүүлэн нэмэгдүүлэхэд газрын харилцааны чиглэлээр дэмжлэг үзүүлэх, авч хэрэгжүүлэх санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар байгуулагдсан тус газрын болон орон нутгийн мэргэжилтнүүдийн шинээр бий болсон болон шинэчлэгдсэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан иргэн, хуулийн | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/87 дугаар тушаалаар байгуулагдсан Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/176 дугаар тушаалаар батлагдсан Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга;<br>- Газрын даргын 2024 оны А/177 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн нарийн бичгийн дарга;<br>- Газрын даргын 2024 оны А/264 дүгээр тушаалаар байгуулагдсан байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг.<br>Ажлын хэсэгт ажилласан ажлын тайлан, тушаалын хэрэгжилтийг тухай бүр тайлагнан ажиллаж байна. | | |
| 17 | Арга хэмжээ 6.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтүүдийг хуулийн хугацаанд тухай бүр тайлагнан холбогдох хүргүүлэн ажиллаж байна. | 01.02-12.10 | 100 |
| 18 | Арга хэмжээ 6.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь | Тайлант хугацаанд нийт 29 албан бичиг газрын даргаас цохогдон ирсэн бөгөөд нийт 8 албан бичгийг боловсруулж, нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ, бусад байгууллагад хүргүүлсэн байна. Үүнд: | 01.02-09.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж ажиллах | | | шийдвэрлэсэн байна. | - Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн "Монголын эдийн засгийн чуулган-Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн"-д оролцох албан тушаалтнуудын мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийн хариуг тус газрын 2024 оны 1/205 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Мөн Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл"-ийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийн хариуг тус газрын 2024 оны 3/289 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Цөмийн энергийн комиссын ажлын албанд "Монгол Улсад тохиромжтой бага чадлын модуляр реакторын тухай" сэдэвт үндэсний семинарт тус байгууллагаас оролцох хүмүүсийн нэрсийг тус газрын 2024 оны 1/3096 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус газарт цохогдсон ирсэн бичгийн бүртгэлийг хөтлөн ажиллаж байна. | | |
| 19. | Арга хэмжээ 6.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын нэгдсэн тайланг байгууллагын архивт зохих шаардлагыг хангаан хүлээлгэн өгсөн. | 01.02-06.28 | 100 |

## ХОЁР. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын тайланг нэгтгэн, нэгдсэн тайланг гарган, танилцуулга бэлдэн Газрын даргын дэргэдэх Зөвлөлийн хуралд танилцуулах | Ажлын тайлан, холбогдох мэдээлэл | - | Ажлын тайлан Засгийн газарт танилцуулагдсан байх. | Газрын даргын 2023 оны А/190 дүгээр тушаалаар байгуулагдсан Өмнөговь аймгийн Ханбогд суманд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн Газрын кадастрын цахим системд Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд газар эзэмшүүлж, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, ажлын хэсгийн тайланг нэгтгэж, танилцуулга бэлдэн Газрын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралд танилцуулан Засгийн газарт танилцуулахаар дэмжигдсэн. | 01.02-01.29 | 100 |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Монгол Улсын Ерөнхий сайд тус газарт ажиллахтай холбогдуулан Ерөнхий сайдаас өгөх үүрэг, чиглэлийн төслийг боловсруулах | 1 бичиг | - | Ерөнхий сайдаас өгөх үүрэг, чиглэлийн төсөл боловсруулагдсан байх. | Монгол Улсын Ерөнхий сайд тухайн агентлагт ажиллах төлөвлөгөөний төсөлд тусгагдсаны дагуу Ерөнхий сайдаас өгөх үүрэг, чиглэлийн төслийг боловсруулан Газрын даргад танилцуулсан. | 02.01-02.28 | 100 |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Тус газрын дэргэд ажиллах Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн ажиллах журмыг | 1 журам | - | Журам нь газрын даргын тушаалаар батлагдсан байх | Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, тус газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулан батлуулах, зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах | | | | тусгагдсаны дагуу тус газрын дэргэд ажиллах Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн ажиллах журам болон Зөвлөлийн бүрэлдэхүүний төслийг боловсруулж, танилцуулга бэлдэн Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 03-р сарын 21-ний өдрийн хуралд танилцуулан газрын даргын 2024 оны А/120 дугаар тушаалаар батлуулсан. Мөн тухайн зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2024 оны А/177 дугаар тушаалаар батлуулав. 2024 онд тус зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг гарган танилцуулах ажлыг хийж гүйцэтгэв. | 03.15-06.28 | 100 |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Тус газрын стратегийн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн батлагдсантай холбогдуулан шинээр бий болсон болон шинэчлэгдсэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, хянах | 11 албан тушаалын тодор-хойлолт | ТАЗ-ийн тогтоолоор 2023 онд батлагдсан. | Албан тушаалын тодорхойлолтууд боловсрогдсон байх | Газрын судалгаа шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газрын дарга болон 4 ахлах мэргэжилтэн, 1 мэргэжилтэн, Газрын биржийн хэлтсийн дарга, 3 мэргэжилтэн, Кадастрын хэлтсийн 1 мэргэжилтэн, Газар зохион байгуулалтын хэлтсийн 2 мэргэжилтэн, Газрын мониторингийн хэлтсийн 1 мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хянан боловсруулж, харьцуулалт, танилцуулга бэлдэн Төрийн захиргаа, удирдлагын газарт өгсөн. | 03.10-06.28 | 100 |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Газрын харилцааны салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойд зориулсан номын хэвлэлийн эх бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт | 3 төрлийн мэдээлэл | | Мэдээллийг бэлтгэн номын эх бэлтгэлд оруулсан байх | Газрын даргын тушаалын хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу дараах мэдээллийг бэлтгэлээ. Үүнд:<br>• газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүсэл хөгжлийн түүх (1954-2024); | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллан хуваарийн дагуу мэдээ мэдээлэл бэлтгэх | | | | • Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн мэдээлэл;<br>• ОХУ-ын Москва хотын Газар зохион байгуулалтын их сургуулийн танилцуулга, тухайн сургуулийн төгсөгчдийн мэдээлэл;<br>• 1954 оноос хойш кадастрын чиглэлээр хийгдсэн ажлын танилцуулга;<br>• Газрын судалгаа, шинжилгээ бодлого төлөвлөлтийн газрын бүтэц, үйл ажиллагааны талаарх танилцуулга; | 08.15-09.30 | 100 |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн баярын хуралд оролцох хүмүүсийн нэрс гаргаж удирдлагад танилцуулах | 6 төрлийн нэрсийн жагсаалт | | Нэрсийн жагсаалтыг гаргаж, газрын удирдлагад танилцуулагдсан байх | Төрийн ордонд зохион байгуулагдах Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн баярын хуралд оролцох нийт 600 хүний нэрсийн жагсаалтыг доорх газар, байгууллагаас гаргаж, газрын удирдлагад танилцуулан хянуулав. Үүнд:<br>- Төрийн дээд болон төрийн захиргааны байгууллагын төлөөлөл<br>- Хамтран ажиллаж буй төсөл, хөтөлбөрийн төлөөлөл<br>- салбарын төрийн бус байгууллага<br>- их, дээд сургууль<br>- салбарын ахмад ажилтнууд<br>- агентлагийн ажилтнууд<br>- нийслэл, дүүрэг, орон нутгийн ажилтнууд | 11.25-12.05 | 100 |

## ГУРАВ. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдах | Сургалтын тоо | - | Сургалтанд хамрагдсан байна. | Байгууллагаас зохион байгуулагдсан дараах сургалт, мэдээллийн цагт хамрагдсан. Үүнд:<br>- 2024 оны 3 дугаар сарын 26-29-нд FASEP Mongolia төслийн "Бэлчээрийн төлөв байдлыг үнэлэхэд хиймэл дагуулын арга зүйг хөгжүүлэх, FASEP платформын танилцуулга" сэдэвт сургалт;<br>- 2024 оны 04 дүгээр сарын 05-нд зохион байгуулагдсан "Албан хэрэг хөтлөлтийн арга зүй" сургалт;<br>- Франц Улсын 3 байгууллагын консерциумын хэрэгжүүлсэн төслийн хаалтын зөвлөлдөх уулзалт, сургалт;<br>- 2024 оны 02 дугаар 29-ний өдөр зохион байгуулагдсан "Ажил амьдралын тэнцвэр" сургалт;<br>- 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан "Байгууллагадаа хувь нэмэр оруулах нь" лекц;<br>- МЭХ-ны ерөнхийлөгч Б.Оюунгэрэлийн "Хамгийн дулаахан газар" сэдэвт лекц;<br>- Хөдөө аж ахуйн их сургууль дээр зохион байгуулагдсан "Газрын харилцаа 2024" эрдэм шинжилгээний хурлын "Кадастртай холбоотой асуудлууд" салбар хуралдаан;<br>- Монгол Улсад зохион байгуулагдсан Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар олон улсын хурал; | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт сургалт. | | |
| 2 | Арга хэмжээ 2. Монгол хэл бичгийн сургалтанд хамрагдах, бие даан суралцах | Сургалтын тоо | - | Сургалтанд хамрагдсан байна. | Монгол бичгийг https://training-mongolia.thinkific.com/enrollments линкээр бие даан суралцаж, анхан шатны цахим хичээлүүдийг үзэж дуусгасан. | 01.02-12.10 | 90 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

**ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН**
*(Албан тушаал )*

................................ **Х.ЭНХЖАРГАЛ**

**2024.12.05**
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: *Газрын харилцааны стратеги, бодлого төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Энхжаргал*

Ярилцлага хийсэн огноо: *2024 оны 12 сарын 05 өдөр*

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| 1. | Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажилд анхаарч ажиллах | Хугацаанд нь чанартай гүйцэтгэх /анхаарах | |
| 2. | Газрын чиг үүргийн дагуу судалгаа, шинжилгээний ажлыг чиглэх. | Тодорхой ажлыг санаачлан гүйцэтгэх | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА ................................ /А.АМАРСАЙХАН/

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)*